



БЭРС-2

ХӨРӨНГӨӨР

БАТАЛГААЖСАН
ҮНЭТ ЦААС

ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ:
БЭРС ЭЙ БИ ЭС ПЛАС ТЗК ХХК


ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ

Үнэт цаас гаргагч “Бэрс Эй Би Эс Плас” ХХК нь анх 2022 оны 11 сарын 10-ны өдөр хязгаарлагдмал хариуцлагатай компани хэлбэрээр үүсгэн байгуулагдаж, СЗХ-ны 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 28 тоот тогтоолоор хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авч Бэрс Эй Би Эс Плас ТЗК ХХК болж өөрчлөгдсөн байна.


ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧИЙН ТУХАЙ

Бэрс Финанс ББСБ ХХК нь 2017 оноос үйл ажиллагаа явуулж эхэлсэн бөгөөд 100%-ийн хувьцаа эзэмшигч буюу толгой компани нь Бэрс Капитал ХХК юм. Тус компани нь өдгөө 21 салбар, 80 гаруй ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. Салбаруудаас 2 нь Улаанбаатар хот, 19 нь орон нутагт харьяалагдаж байна.

ЗЭЭЛИЙН БАГЦ, САЯ₮




ЧАНАРГҮЙ ЗЭЭЛ




2020-2022 оны хооронд зээлийн багц 2.2 дахин нэмэгдсэн ч зээлийн оновчтой менежментийг хэрэгжүүлснээр чанаргүй зээлийг 3 дахин бууруулж чадсан байна.

САНХҮҮГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД


НИЙТ ХӨРӨНГӨ, САЯ₮




ӨӨРИЙН ХӨРӨНГӨ, САЯ₮



ХҮҮГИЙН ОРЛОГО, САЯ₮



ЦЭВЭР АШИГ, САЯ₮



ХӨРӨНГИЙН БАГЦЫН ҮЗҮҮЛЭЛТ

ХӨРӨНГИЙН БАГЦ
₮10 тэрбум

ГЭРЭЭНИЙ ТОО
2,318

ЗЭЭЛИЙН ЧАНАР
100% хэвийн

ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ

Нэрлэсэн үнэ	100,000 төгрөг
Санал болгож буй тоо ширхэг	90,000 ширхэг
Татан төвлөрүүлэх нийт дүн	9,000,000,000 төгрөг хүртэл
Үнэт цаасны хугацаа	24 сар
Үнэт цаасны хүү	19.2%
Үнэт цаасны хүү төлөх давтамж	Улирал бүр
Үндсэн төлбөр төлөгдөх давтамж	Жилд 1 удаа
Үнэт цаасны хүүд ногдох татвар	5%

1

ТОГТМОЛ ӨГӨӨЖ

Хөрөнгө оруулалтаас орж ирэх мөнгөн урсгал, хугацаа тодорхой байдаг.

2

ЭРСДЭЛ БАГА

Хууль болон санхүүгийн шаардлага хангасан 100% хэвийн зээлийн багц

3

ХӨРВӨХ ЧАДВАР ӨНДӨР

Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан арилжаалагдах учир хугацаанаас нь өмнө борлуулах боломжтой.

4

ТАТВАРЫН ДАРААХ ӨГӨӨЖ ӨНДӨР

Нээлттэй өрийн хэрэгслийн хүүгийн орлогын албан татвар 5 хувь байдаг.

БЭРС-2 ХБҮЦ-НЫ ӨГӨӨЖ

2023 оны 1 дүгээр сарын байдлаар арилжааны банкнуудын шинээр татсан жигнэсэн дундаж жилийн төгрөгийн хадгаламжийн хүү 12.3 хувь, инфляцын түвшин 13.2 хувь буюу хадгаламжийн бодит өгөөж - 0.9 хувьтай байна.

Үнэт цаас гаргагчийн санал болгож буй Бэрс-2 Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас нь 19.2 хувийн түвшинд буюу бодит өгөөж 6 хувьтай байгаа нь төгрөгийн хадгаламжийн жигнэсэн дундаж хүүтэй харьцуулахад нэрлэсэн хүүгийн түвшинд 1.56 дахин өндөр өгөөжтэй байна.



ХБҮЦ-НЫ ӨГӨӨЖ

Улирал	Үндсэн төлбөр	Татварын дараах хүүгийн орлого	Нийт мөнгөн орлого	Дахин хөрөнгө оруулалт хийвэл	
				Хүүгийн орлого	Нийт
1	-	456,000	456,000	-	456,000
2	-	456,000	456,000	-	456,000
3	-	456,000	456,000	-	456,000
4	5,000,000	456,000	5,456,000	-	5,456,000
5	-	228,000	228,000	228,000	456,000
6	-	228,000	228,000	228,000	456,000
7	-	228,000	228,000	228,000	456,000
8	5,000,000	228,000	5,228,000	228,000	5,456,000
Нийт	10,000,000	2,736,000	12,736,000	912,000	13,648,000

Хадгаламжийн өгөөж

Үндсэн төлбөр	Татварын дараах хүүгийн орлого	Нийт мөнгөн орлого
-	-	-
-	-	-
-	-	-
-	-	-
-	-	-
-	-	-
-	-	-
-	-	-
10,000,000	2,214,000	12,214,000
10,000,000	2,214,000	12,214,000

Хэрэв 10 сая төгрөгийг Бэрс-2 ХБҮЦ-д хөрөнгө оруулалт хийсэн тохиолдолд улирал тутам хүү, жил тутам үндсэн төлбөрийг хүлээн авах бөгөөд 24 сарын хугацаанд нийт 12,736,000 төгрөг хүлээн авна. Харин хүлээн авсан үндсэн төлбөрийг дахин хөрөнгө оруулалт хийсэн тохиолдолд нийт 13,648,000 төгрөг хүлээн авна.

Харин 10 сая төгрөгийг банкны хадгаламжид жилийн 12.3 хувийн хүүтэй, 24 сарын хугацаанд хадгалуулсан тохиолдолд хугацааны эцэст нийт 12,214,000 төгрөг хүлээн авна.

ЗАХИАЛГА ӨГӨХ ЗААВАР

1. Үнэт цаасны данс нээх

Өөрийн сонгосон үнэт цаасны компанид данс нээлгэнэ. /Голомт Капитал ҮЦК ХХК-ийг сонгосон тохиолдолд “Golomt Capital” аппликэйшн суулгаж онлайнаар нээлгэх боломжтой/

2. Мөнгөө байршуулах

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийн дансанд мөнгөө байршуулах

3. Захиалга өгөх

Захиалгын онлайн сувгууд эсвэл захиалгын хуудсаар дамжуулан захиалгаа өгөх

4. Захиалга баталгаажих

Захиалгын дагуу таны үнэт цаасны дансанд Бэрс-2 ХБҮЦ байршина.

ХОЛБОО БАРИХ



7012-1530

8688-9922

8083-7744



info@golomtcapital.com